



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Г Тогтоол хүчингүй болгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Холбогдох хууль хүчингүй болсон, шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй дараах тогтоолууд болон тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

1.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн журам батлах тухай” 18/15 дугаар тогтоол

1.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 12/37 дугаар тогтоол

1.3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт төлбөртэй зогсоолын талаар авах зарим арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоол

1.4. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Авто зам ашигласны төлбөрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 71 дүгээр тогтоол

1.5. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны “Хувьчлалын арга хэлбэр тогтоох тухай” 60 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх заалт

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1113100237